



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Ногоон байгууламжийн чиглэлээр 2019 онд хийгдэх ажлын жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Хавсралтад дурдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор байгуулсугай.

3. Төсөл арга хэмжээний ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР


Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 04 сарын 07
 өдрийн тушаалын дүгээр хавсралт



НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ ЧИГЛЭЛЭЭР
 2019 ОНД ХИЙГДЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

д/д	Ажлын нэр	Тоо хэмжээ	Зарцуулах хөрөнгө /сая.төг/
1	Улаанбаатар хотын ногоон байгууламжийн мод сөөгний орчны бохирдлыг тэсвэрлэх чадварын судалгаа /модлог ургамлын анатоми физиологиын зуны судалгаа/	9 дүүрэг	10.0
2	Улаанбаатар хотын ногоон байгууламжийн мод сөөгний орчны бохирдлыг тэсвэрлэх чадварын судалгаа /модлог ургамлын анатоми физиологиын өвлийн судалгаа/	9 дүүрэг	8.0
3	Азофос амьд бактерийн бордоо худалдан авах	2.6тн	8.0
4	Ногоон байгууламжийн үйл ажиллагаанд ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ, баталгаажуулалт	Ногоон байгууламжийн үйл ажиллагаанд	40.0
5	Ногоон байгууламжийн стандарт шинээр нэмэгдүүлэх, шинэчлэн боловсруулах	5	10.0
6	Шилмүүст модонд дуслын шингэн хийх ажил хавар	2509ш	10.0
7	Шилмүүст модонд дуслын шингэн хийх ажил намар	2090ш	10.0
8	Шилмүүст модонд микоризын бордоо хийх ажил хавар	225кг	10.0
9	Ногоон байгууламжийн мод сөөгний ургалтыг сайжруулах холимог бордоо хийх ажил хавар	5,0тн	10.0
10	Ногоон байгууламжийн мод сөөгний ургалтыг сайжруулах холимог бордоо хийх ажил намар	5,0тн	10.0
11	Ногоон байгууламжийн мод сөөгний ургалтыг сайжруулах холимог бордоо хийх ажил намар	4,5тн	10.0
12	Байгалийн чулуун бордоо худалдан авах, модонд чулуун бордоог хийх ажил	10тн	5.0
13	Оршуулгын газрыг ойжуулах	70000ш хайлаас	50.0
14	Хэлбэржүүлэлт хийх ажил Үүнд: 1. Хэлбэржүүлэлтээс гарсан хог хаягдлыг тээвэрлэх 1. Хэлбэржүүлэлтийн бригадын зардал	6 дүүрэг 400м ³ 4 бригад	350.0 28.0 322.0
	ДҮН		541.0

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 07 сарын 07
өдрийн 11 тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төхижилт хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төхижилт хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Нааяа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төхижилт хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Төхижилт хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн